



МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
И-мэйл: comcor@iaac.mn, Вэб сайт: http://iaac.mn

2022.09.12 № 05/11656
танай -ны № -т

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА С.БАТБОЛД
ТАНАА

Г Хувийн ашиг сонирхлын урьдчилсан
мэдүүлэг хянасан тухай

Зам тээврийн, хөгжлийн яамны Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын авто замын сүлжээний бүртгэл, тусгай зөвшөөрөл хариуцсан мэргэжилтний албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн Жанчивдоржийн Оюунжаргалын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянан үзэхэд ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Нэр дэвшигч нь тухайн албан албан тушаалд томилогдсон тохиолдолд Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3-т заасан хугацаанд хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг, тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөл байдалд дээрх хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж байх, мөн хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллахад анхаарна уу.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА
ЭРХЭЛСЭН КОМИССАР

Т.ЭНХБОЛД



1422003016114